



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар A/472

Улаанбаатар хот

Нийслэлийн Баянгол дүүргийн  
Боловсролын хэлтсийн эргэлтийн бус хөрөнгийг  
Балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3,020,613 (гурван сая хорин мянга зургаан зуун арван гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Нийслэлийн ерөнхий боловсролын 146 дугаар сургуулийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс (З.Энхгэрэл)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 146 дугаар сургууль (Д.Нямсүрэн)-д даалгасугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс (З.Энхгэрэл)-т, Нийслэлийн ерөнхий боловсролын 146 дугаар сургууль (Д.Нямсүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001273



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/422 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Ширээний компьютер	Hassee	2016	ш	1	1,449,000.00	1,449,000.00	1,424,850.00	24,150.00	Нийслэлийн ерөнхий боловсролын 146 дугаар сургууль
2	Ширээний компьютер	Dell	2019	ш	1	1,571,613.00	1,571,613.00	753,064.00	818,549.00	
Нийт балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн							3,020,613.00	2,177,914.00	842,699.00	